



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/78

Батноров сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.3, 19.2.4, 19.3.3, 19.3.4, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.3, 20.1.5 дахь заалтыг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянбулаг 4 дүгээр багийн малчин О.Төмөрбаатарын суурийн үхэрт Галзуу өвчин гарсан болох нь Хэнтий аймгийн мал эмнэлгийн лабораторийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны 24-159 дугаар бүхий хариугаар “Галзуу” өвчин батлагдсан тул “Өвөр домбон” гэх газарт 5 км –ийн радиуст хорио цээрийн дэглэмийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс тогтоосугай
2. Голомтын өрх О.Төмөрбаатарын гэр бүлийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (П.Лхагвасүрэн)-д даалгасугай.
3. Галзуу өвчинтэй тэмцэх заавар хэрэгжүүлж, холбогдох газрыг мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллахыг Энхсүрэг вет мал эмнэлгийн малын эмч (Г.Өсөхбаяр)-д үүрэг болгосугай.
4. Галзуу өвчинтэй тэмцэх арга хэмжээний мэдээ тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д даалгасугай.
5. Хорио цээрийн дэглэм тогтоосон өрхийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Баянбулаг багийн Засаг дарга (М.Баяржаргал)-д даалгасугай.
6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР